

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР, ТҮҮНИЙГ ХЭМЖИХ НЬ

Г.Гантулга\*

**Хураангуй:** Улс орны эдийн засагт тухайн улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудын үүрэг, оролцоо чухал байдаг. Тиймээс ч олон улсад аж ахуй нэгжүүдийн үүрэг, оролцоог чухалчлан үзэж, аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайлангийн чанартай мэдээллийг санхүүгийн мэдээлэл хэрэглэгчид ихээхэн сонирхох болсон. Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчид болох хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарын асуудалд түлхүү анхаарч байна. Олон улсад санхүүгийн тайлагналын чанарыг олон аргаар (СТОУС нэвтрүүлэлт (IASB, 2009), аккурэль суурьт загвар зэргийг ашиглан) хэмждэг.

Судалгааг санхүүгийн тайлагналын мэдээллийн чанар Монгол улсад ямар түвшинд байгааг илрүүлэх зорилгоор хийсэн болно. Ингэхдээ хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын санхүүгийн тайлагналын олон улсын стандартын хэрэглээ, ач холбогдол санхүүгийн тайлангийн чанарын түвшинг тодорхойлох зорилго тавин судалсан. Судалгаанд макро орчны нөлөөллийг орчны шинжилгээний PESTLE+G арга хэрэглэн судалж алдааны модны аргаар санхүүгийн тайлангийн чанарт нөлөөлөх гол хүчин зүйлийг тодорхойлсон.

Санхүүгийн тайлагналын чанарыг хоёр чиглэлээр судалсан. Эхний чиглэл нь СТОУС-н чанарын хэмжигдэхүүнүүдийг судалж, СТОУС-ын нэвтрүүлэлтийн түвшинг аж ахуй нэгжүүдийн нягтлан бодогчдоос асуулгын аргаар судалгаа авсан.

Нөгөө чиглэл нь аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайлангийн мэдээлэл ашиглан аккурэль суурьт загвараар санхүүгийн тайлагналын чанарыг үнэлсэн. Үнэлгээг бодитой гаргахын тулд эхлээд аккурэль суурьт загваруудыг судлахад мөнгөний урсгалын бүх түвшинд хэрэглэх боломжтой

---

1 СЭЗИС-ийн дэд профессор, МНБ, ТИНБ (Email) gantulga.g@ufe.edu.mn

шинэчлэгдсэн Жонсын загвар сонгогдсон. Энэ загвараараа хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй II самбарт байрлах бүх 77 компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг панел өгөгдөл болгон хэмжиж үзсэн болно.

**Түлхүүр үгс:** аккруэл зарчим, санхүүгийн тайлангийн мэдээлэл, мэдээллийн чанар, НББ-ийн тогтолцоо, дискрипшн аккруэль, шинэчлэгдсэн Жонсын загвар

## Оршил

Улс орны эдийн засагт тухайн улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудын үүрэг, оролцоо чухал байдаг. Тиймээс ч олон улсад аж ахуй нэгжүүдийн үүрэг, оролцоог чухалчлан үзэж, аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайлангийн чанартай мэдээллийг санхүүгийн мэдээлэл хэрэглэгчид ихээхэн сонирхох болсон. Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчид болох хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарын асуудалд түлхүү анхаарч байна. Дэлхийн банкны 2008 онд хийсэн судалгаагаар Монголын санхүүгийн тайлангийн чанар доогуур /50 хувиас бага/ гэсэн ерөнхий дүгнэлт гарсан.<sup>2</sup> Мөн зарим судалгаанд СТОУС-ийн хэрэгжилтийн байдал 90 орчим хувьтай<sup>3</sup> гэж гарсан байна. Олон улсын практикаас харахад СТОУС нэвтэрснээр санхүүгийн тайлагналын чанар дээшилдэг гэж үздэг. Монгол улсын хувьд СТОУС-ийн хэрэгжилт өндөр хувьтай байгаа боловч санхүүгийн тайлагналын чанар доогуур гэсэн дүгнэлт гарсан байгаа нь олон улсын практиктай зөрчилдөж байгаа юм.

## Судалгааны зорилго

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын санхүүгийн тайлангийн чанарыг тодорхойлж, үр дүнг нь сайжруулсан Жонсын загвар (modified Jones model)-аар үнэлж, санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд ашиглагдахуйц мэдээллээр хангах нөхцлийг нэмэгдүүлэх, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарыг сайжруулах арга замыг тодорхойлох явдал юм.

---

2 [http://www.frc.mn/index.php/2013-02-18-01-47-04/2013-11-20-02-35-12/doc\\_view/2924-](http://www.frc.mn/index.php/2013-02-18-01-47-04/2013-11-20-02-35-12/doc_view/2924)

3 [http://119.40.100.197/pages/File/NBBBH-iin\\_Ulsiin\\_uzleg.docx](http://119.40.100.197/pages/File/NBBBH-iin_Ulsiin_uzleg.docx).

### Судлагдсан байдлын судалгаа:

Сүүлийн жилүүдэд ашгийн удирдлагын талаарх судалгаа ихээхэн хийгдэж байна. Энэ төрлийн судалгаанд ихэвчлэн ашгийн удирдлагыг шалгахын тулд дискришн аккурэль загварыг ашиглан судалж байна. СТОУС-д зааснаар аккруэль суурьт зарчмаар орлого, зардлаа хүлээн зөвшөөрч бүртгэн, цэвэр ашгийг тайлагнахыг зөвлөдөг. Компаний удирдлагууд ямарваа нэг ашиг сонирхлын үүднээс компаний ашгийг бодит байдлаас өсгөх эсвэл бууруулж байдаг (агентийн онол) бөгөөд энэ нь аккруэль суурьт зарчмыг зөрчиж байгаа явдал юм. Эндээс аккруэль суурьт зарчмыг зөрчсөнөөр холбогдох НББ-ийн стандартыг зөрчихөд хүргэдэг учраас чанаргүй санхүүгийн тайланд хүргэдэг. Энэ нь байгууллагын санхүүгийн мэдээлэлд үндэслэн байвал зохих аккруэлийг тооцон бодит аккруэлтэй харьцуулах замаар хэмждэг. Энэ зөрүүг дискришн аккурэль гэж нэрлэж байгаа бөгөөд дискришн аккурэль илэрсэн тохиолдолд аккруэль суурийг зөрчсөн гэж үзэж санхүүгийн тайлагналын чанарыг хэмждэг. Өөрөөр хэлбэл, ашгийн удирдлага байгаа үед аккруэль суурийг зөрчин орлого, зардлыг бодитоос өөрөөр илэрхийлсэн гэж үзэх ба энэ тохиолдолд санхүүгийн тайлангийн чанар сайн гэж үзэх боломжгүй болно. Дискришн аккруэлийг бодит аккруэлээс хүлээгдэж байгаа аккруэлийг хасаж тооцно. “Дискришн аккруэл”-ийг хэмжих Healy (1985), DeAngelo (1986), Jones (1991), Modified Jones (1995), Industry гэсэн загварууд түгээмэл хэрэглэгддэг.

Дээрхи загваруудыг ашигласан 66 орчим судалгааны ажил байдгаас (хавсралт №1-аас харна уу) Modified Jones загвараар улс орнуудын санхүүгийн тайлангийн чанарын индексийг тодорхойлж харьцуулдаг.<sup>4</sup> Эдгээр судалгааны ажлууд голчлон тухайн улсынхаа хөрөнгийн бирж дээрх хувьцаат компаниудаас санамсаргүй байдлаар сонгон хугацааны цувааны (time series) болон хөндлөн огтлолын (cross-section) өгөгдөл цуглуулан Жонсын бүлгийн загваруудаар ашгийн удирдлагыг илрүүлэх тооцоолол хийсэн байдаг. Судалгааны дүгнэлтэнд загварт үнэлэгдээгүй үлдсэн бусад хүчин зүйлсийг судалж үзэхийг мөн зөвлөсөн байв. Судлаачдын дүгнэлтээр De Angelo загвар стандарт алдаа хамгийн их, Jones болон Modified Jones загвар хамгийн бага стандарт алдаатай байсан. Мөн эдгээр загваруудыг “дискришн биш” аккруэлд хэрэглэх нь тохиромжгүй болохыг анхааруулсан. Modified Jones загвар нь ашгийг удирдлагын зүгээс удирдаж байгаа эсэхийг илрүүлэхэд хамгийн хүчтэй загвар болохыг нотолсон.<sup>5</sup> Орлого болон муу өрийн удирдлагыг илрүүлэхэд Jones болон Modified Jones загварууд илүү хүчтэй. Margin загвар нь өрөөс бусад зарлагын удирдлагыг

4 Qingliang Tang a, Huifa Chen, Zhijun Lin, “How to Measure Country Level Financial Reporting Quality?”, 2011, Australia, China, Hong Kong

5 Patricia M. Dechow, Richard G. Sloan, Amy P. Sweeney, “Detecting Earnings Management”, 2012, USA

илрүүлэхэд илүү тохиромжтой гэх мэт. Хөндлөн огтлолол ба хугацааны цувааны загваруудыг нэгтгэснээр (панел загвар) ойрын ирээдүйн ашгийн удирдлагыг таамаглах боломжтой<sup>6</sup> гэсэн байдаг. Манай улсад СТОУС-н нэвтрүүлэлтийн талаар Дэлхийн банк, Сангийн Яам зэрэг газруудаас судалгааны ажлууд хийгдэж байсан боловч нэвтрүүлсний үр дүнд санхүүгийн тайлангийн чанарт хэрхэн нөлөөлж буйг судалсан судалгааны ажил хараахан хийгдээгүй байна. Тиймээс бид шинэчлэгдсэн Жонсын загвараар панел өгөгдөл ашиглан ашгийн удирдлагыг хэмжсэн болно.

### Судалгааны арга зүй

Судалгааг дараах 3 чиглэлээр хийсэн:

1. Жонсын Шинэчлэгдсэн /Modified Jones/ загвараар Eviews 8.1 программ ашиглан Монголын хөрөнгийн биржэд бүртгэлтэй 77 компанийн санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарыг /аккруэл суурийн тархалт/ үнэлж үзэв.
2. Дээрх 77 хувьцаат компаниудыг хамруулан ерөнхий нягтлангуудаас нь асуулгын аргаар судалгаа авсан.
3. Судалгааны ажлын хүрээнд санхүүгийн тайлагналын орчны хүчин зүйлсийг PESTEL+G шинжилгээгээр судалж үзсэн.

Жонсын Шинэчлэгдсэн /Modified Jones/ загвараар шинжилгээг хийхдээ өгөгдлийг панел өгөгдлийн хэлбэрт бэлтгэж E-views программ руу оруулсан. Панел өгөгдөл нь олон субъектын, олон хугацааны, олон хувьсагчдын мэдээллийн олонлогийг агуулдаг.

Ерөнхий тэгшитгэл нь:  $Y_{i,t} = \beta_1 + \beta_2 X_{2,i,t} + \dots + \beta_k X_{k,i,t} + u_{i,t}$

Үүнд:

- Олон субъект – хувьцаат компанийн тоо – (i=77)
- Олон хугацаа – жилийн тоо (2012-2014 он) – (t=3)
- Олон хувьсагчид –  $(ACC_{i,t}/A_{i,t-1})$ ,  $(1/A_{i,t-1})$ ,  $(\Delta REV_{i,t} - \Delta REC_{i,t})/A_{i,t-1}$ ,  $(PPE_{i,t}/A_{i,t-1}) - (N=4)$

Шинэчлэгдсэн Жонсын загвар:

- $NDA_{i,t} = E (ACC_{i,t}/A_{i,t-1}) = \beta_1(1/A_{i,t-1}) + \beta_2 ( (\Delta REV_{i,t} - \Delta REC_{i,t}) / A_{i,t-1} ) + \beta_3(PPE_{i,t}/A_{i,t-1}) + \varepsilon_{i,t}$
- $r(TA, PPE) > 0.8$  байвал хувьсагчид хоорондоо хамааралтай гэж үзнэ.

6 Eli Bartov Leonard N. Stern, Ferdinand A. Gul and Judy S.L. Tsui, "Discretionary-Accruals Models and Audit Qualifications", 2000, USA

### **Таамаглал**

Санхүүгийн тайлангууд буюу түүнд тусгагдсан үзүүлэлтүүд нь мэдээлэл хэрэглэгчдийн шийдвэр гаргалтанд материаллагаар нөлөөлдөггүй өөрөөр хэлбэл чанаргүй байх. /дискрешн аккруэл хангагдахгүй./

### **Өгөгдөл цуглуулсан арга**

Анкетын арга, ярилцлага ба ажиглалт хийх, экспертийн арга, хоёрдогч мэдээлэлд дүн шинжилгээ хийх, судалгааны загварууд

### **Түүврийн арга, түүврийн хэмжээ**

Хөрөнгийн биржийн II ангилалд хамрах 89 орчим компаниас 77 компанийг түүвэрлэн авч 2012-2014 оны дараалсан 3 жилийн санхүүгийн тайлангийн мэдээллийг ашигласан.

### **Судалгааны хэсэг**

Санхүүгийн тайлангийн орчны хүчин зүйлсийн нөлөө

Санхүүгийн тайлангийн чанарт нөлөөлөх макро орчны хүчин зүйлсийн нөлөөг судлахдаа PEST анализын өргөтгөл болох PESTLE + G аргыг хэрэглэсэн болно. Үүнд:

P – Political /Улс төр/

E – Economic /Эдийн засаг/

S – Social-cultural /Нийгэм соёл/

T – Technological /Технологи/

L – Legal /Хууль/

E – Environmental (Ethic) /Ёс зүй/

G – Governance /Засаглал/

Шинжилгээний үр дүнг тоон хэмжүүрээр илэрхийлэх зорилгоор судлаач экспертүүдтэй хийсэн ярилцлага болон хоёрдогч мэдээллүүдэд үндэслэн хүчин зүйлсийг 1-5 оноогоор /1-муу, дундаас доогуур, 3-дунд, 4-сайн, 5-с маш сайн/ үнэлж үнэлгээ өгсөн үндэслэлийг товч тайлбарлав.

Хуулийн хүчин зүйлсийн нөлөө: СТОУС-ын хэрэгжилт болон хуулийн хэрэгжилт сул байгаа тул 2 оноо өгсөн. Учир нь манай улсын санхүүгийн тайлагналын стандартын хүчин чадал дэлхийн улс орнуудын дундажаас буюу 4.6-оос даруй 0.8 оноогоор бага, 144 орноос 130-р байранд орсон байгаа нь стандартын хүчин чадал сул байгааг харуулж байна.

Улс төрийн хүчин зүйлсийн нөлөө: Санхүүгийн тайлагнал нь улс төрөөс

хараат бус байх ёстой гэтэл манай улсад хэт их нөлөө үзүүлж байна. Иймээс 3 оноо өгсөн. Төр бизнесийн үйл ажиллагаанд хэт их оролцдог. Тухайлбал, төрийн өмчит үйлдвэрийн газрын ТУЗ, гүйцэтгэх удирдлагыг төрийн оролцоотойгоор байгуулдаг ба ингэхдээ ихэвчлэн улс төрийн томилгоо хийдэг. Судалгаанаас үзвэл төрийн өмчийн оролцоотой компаниудын ТУЗ-ийн нийт гишүүдийн 75 хувийг Төрийн өмчийн хороо болон Засгийн газрын яам агентлагийн төлөөлөл бүрдүүлж байна. Мөн татварын бодлого тогтворгүй.

Эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөө: Хөрөнгийн зах зээлийн хөгжил сул байгаа нь санхүүгийн тайлангийн чанарт сөргөөр нөлөөлж байна. Иймд 3 оноо өгсөн. Түүнчлэн, Монголын эдийн засгийн өсөлт 2013 онд 14.4 хувь байсан бол энэ үзүүлэлт 2014 онд 4 хувь, 2015 онд 2.4 хувь байсан бол 2016 онд 1 хувь болж буурсан. 2014 оны эцсийн байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 845 сая америк доллар болж 2008 оныхтой харьцуулбал бараг 12 дахин буурсан байна. 2015 оны гүйцэтгэлээр мөн буурч 500 сая орчим америк доллартай тэнцэж байна<sup>7</sup>.

Нийгэм соёлын хүчин зүйлсийн нөлөө: 3 оноо өгсөн. Мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр нь харилцан адилгүй байгаагаас санхүүгийн тайлангийн чанар шууд хамааралтай. “Монголын нягтлан бодохбүртгэл” ийн түүх нь улсын түүхтэй салшгүй холбоотой хөгжсөн бөгөөд 100 орчим жил орос маягийн хөтлөлт буюутүүхэн өртгөөр бүртгэдэг консерватив хандлагатай бүртгэл хөтөлж, сүүлийн 20 жил Америк маягийн хөтлөлт буюу бодит үнэ цэнийг бүртгэдэг либерал хандлагатай бүртгэл хэрэгжүүлэхээр замнаж байна. 3 сая монголчууд 100-гаадхан жилийн өмнөөс нүүдэлчин соёл иргэншлээс суурин соёл иргэншилд шилжсэн боловч асар хурдтайгаар дэлхийтэй хөл нийлүүлэх шаардлага урган гарсан. Амьдралын хэв маягийн энэхүү өөрчлөлт нь хүмүүсийн сэтгэл, оюуны болоод ёсзүйд асар их өөрчлөлтийг авчирсан. НББ тухай хуулийн 17.3-т зааснаар “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн нягтлан бодох бүртгэлийн ажлыг мэргэжлийн буюу мэргэшсэн нягтлан бодогчоор гүйцэтгүүлэнэ” гэж заасан боловч боловсролын системийн үр ашиггүй байдалтай холбоотойгоор бэлтгэгдэж буй мэргэжилтнүүдийн чанарын түвшин ихээхэн ялгаатай болсон.

Технологийн хүчин зүйлсийн нөлөө: 4 оноо өгсөн. НББ-ийн програмаар СТОУС-ын дагуу санхүүгийн мэдээллийг бэлтгэж байгаа эсэхийг хянах боломжгүй байна. СТОУС шинэчлэгдэх үед програм шинэчлэгдсэн үү гэдэг

<sup>7</sup> Статистикын эмхэтгэл 2016

нь тодорхойгүй байдаг. Мөн 2011 онд цахим гарын үсгийн тухай хууль батлагдсан бөгөөд санхүүгийн тайлангийн баталгаажилт электрон хэлбэрээр явагдах боломжтой болсон. Үүний үр дүнд төр болон аж ахуйн нэгжүүд тус тусдаа ажил гүйлгээ боловсруулах үйл ажиллагааны мэдээллийн системийг нэвтрүүлсэн. Одоогоор 11 компани Сангийн Яамнаас Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж нийлүүлэхээр эрх аваад байна. Цаашид удирдлагын шийдвэр гаргалтад туслах болон удирлагыг дэмжих үүрэг бүхий удирдлагын түвшний, стратегийн түвшний системүүдийг төрийн хэрэгжүүлэгч болон хяналтын байгууллагуудад нэвтрүүлэх ба төрийн байгууллагын нэгдсэн нэг мэдээллийн санг бий болгох хэрэгтэй байна. Энэ төрлийн улсын хэмжээний программын архитектурыг хийх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Ёсзүйн хүчин зүйлсийн нөлөө: 2 оноо өгсөн боловч хэрэгжилт нь муу. Ёсзүйн зөрчлийг илрүүлэх, хянах, мониторинг хийх тогтолцоо байхгүй. Одоогоор манай улсад ММНБИ-с баталсан мэргэшсэн нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм, дотоод аудиторын ёс зүйн дүрэм гэж байдаг ч хэрэгжилт хангалтгүй байна.

Компанийн засаглалын нөлөө: 1 оноо өгсөн. Компанийн удирдлага санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх ач холбогдлыг ойлгодоггүй. 2013 оны Монгол улсын компанийн засаглалын үндэсний тайланд Хувьцаат компанийн засаглалын үнэлгээ муу гэсэн дүгнэлт гарсан.

Олон Улсын байгууллагуудын өгсөн үнэлгээнээс харахад санхүүгийн мэдээлэл бэлтгэх тогтолцоо сул байгаа гэсэн нь батлагдаж байна. Тухайлбал Дэлхийн банкнаас гаргасан “өрсөлдөх чадварын индекс”-ийн зарим үзүүлэлтээс үүнийг харж болох юм. 2016 оны байдлаар засгийн газрын газрын зохицуулалтын хямрал 82/138, засгийн газрын шийдвэр гаргалтын олон нийтэд нээлттэй байгаа байдал 72/138, компаний ёс зүй 115/138, Санхүүгийн тайлагнал ба аудитын чадавхи 127/138, компаний төлөөлөн удирдах зөвлөлийн үр ашигтай байдал 133/138, бага хэмжээний хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах байдал 127/138, хөрөнгө оруулалтыг хамгаалах чадвар 8/138, бизнесийн удирдлагын боловсрол олгох үйл ажиллагааны чанар 132/138 тус тус байна. Эдгээр үзүүлэлтүүдийг өмнөх 3 жилийн өмнөх үзүүлэлттэй харьцуулбал харьцангуй буурсан /хөрөнгө оруулалтыг хамгаалах чадвараас бусад/ үзүүлэлттэй байгаа нь цаашид төр засаг, мэргэжлийн байгууллагуудын зүгээс олон талт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Орчны хүчин зүйлсд өгсөн үнэлгээг графикаар харуулбал дараах байдалтай байна.

Зураг1. Гадаад орчны хүчин зүйлсд өгсөн үнэлгээ



### Асуулгын аргаар санхүүгийн тайлангийн чанарыг хэмжих нь

2015 оны байдлаар хөрөнгийн биржид<sup>8</sup> бүртгэлтэй II ангилалд багтах 89 орчим аж ахуй нэгж байгаагаас 77 хувьцаат компанийг түүвэрлэн авч санхүүгийн тайлагналын чанарыг үнэлсэн. (Асуулгын хуудсыг хавсралт N2-с харна уу) Ингэхдээ санхүүгийн тайлагналын чанарын хэмжигдэхүүнүүд болон ашгийн удирдлагыг илрүүлэх аккурель загварыг ашиглан үндсэн 2 чиглэлээр судалгааг хийсэн.

Санхүүгийн тайлагналын чанарын хэмжигдэхүүнүүдийн тусламжтай санхүүгийн тайлагналын чанарыг үнэлэхдээ Бээст, Браам, Боеленс (2009) нарын судалгаанд үндэслэсэн болно. Судалгааг хийхдээ санхүүгийн тайлангийн чанарын хэмжигдэхүүн бүрт харгалзах асуултыг тавьж, асуулт тус бүрт 1-5 оноог өгсөн. Түүвэрлэн сонгосон 77 хувьцаат компаниудын дундаж оноог гарган санхүүгийн тайлагналын чанарыг үнэлсэн.

<sup>8</sup> Бизнес регистрийн сан: Үндэсний статистикийн газраас гаргасан бизнесийн ААН-үүдийн тоо



Хүснэгт 1. Санхүүгийн тайлагналын чанарын  
хэмжигдэхүүнүүдийн ерөнхий статистик

Хэмжигдэхүүнүүд	Асуултууд	Mean	SD
O1	Жилийн санхүүгийн тайлангийн тодруулгаа бүрэн гүйцэд бөглөдөг үү?	4,0588	1.22330
O2	Санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт тэмдэглэл (хаалтанд байгаа утга)-ийг хангалттай бөглөсөн байдал	4.0392	0.72002
	Ойлгомжтой байдлын дүн	4.0490	0.78266
X1	НБББББ-ийн хангалттай, зохистой байдал	4.1373	0.84899
X2	НБББББ-ын өөрчлөлт гарвал тодруулж, тооцооллын өөрчлөлт гарвал өмнөх үеийн тайлангаа залруулдаг уу?	2.3529	1.05496
X3	Санхүүгийн жилийн тайландаа санхүүгийн шинжилгээг ашигладаг эсэх	3.1961	1.05867
	Харьцуулагдах байдал нийт дүн	3.2288	0.66161
Ц1	НББ-н хуулийн хугацаанд тайлангаа тушаадаг уу?	4.8267	0.40098
Ц2	Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хаалтын өдрөөс хойш хэдэн өдрийн дараа аудитор гарын үсэг зурдаг	3.3725	1.45548
	Цаг хугацаандаа байх хэмжигдэнүүний дүн	4.1176	0.77193
Y1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн төрлөө нэрлэнэ үү?	4.2941	0.54015
Y2	Санхүүгийн тайлангийн үр дүнг хэлэлцэх үед сөрөг мэдээлэлд тодруулга хийдэг шиг, эерэг мэдээнд тодруулга хийдэг үү?	4.0392	0.97900
	Үнэн зөв байх нийт дүн	4.1667	0.64550
У1	Жилийн тайланд ирээдүйн таамаглалын талаарх мэдээлэл оруулдаг эсэх	3.0588	1.28704
У2	Түүхэн өртгийн оронд бодит үнэ цэнэ хэрэглэдэг үү?	3.4706	1.17223
У3	Жилийн тайланд учирч буй эрсдэл, бизнесийн одоогийн боломж гэх мэт мэдээллийг оруулдаг эсэх	3.2941	1.18818
	Уялдаа холбоотой байх хэмжигдэхүүний дүн	3.2745	0.93263
	Нийт хэмжигдэхүүний дудаж	3.7673	0.39229

Жич: Асуулт бүрт 5 хариулт өгсөн ба хариулт бүрт харгалзах оноог өгсөн. Ингэхдээ 5 оноо нь хамгийн сайн үр дүнг харуулж байгаа болно.

Хүснэгт 2.4.-т санхүүгийн тайлагналын чанарын хэмжүүрүүдийн ерөнхий статистикийг хэмжсэн. Ингэхдээ ойлгомжтой байх, харьцуулагдах, цаг хугацаандаа байх, үнэн зөв байх, уялдаа холбоотой байх гэсэн 5 хэмжигдэхүүнийг ашигласан. Бээст, Браам, Боеленс (2009) нарын судалгаанд үндэслэн асуулт бүрт 5 хариулт өгсөн. Ингэхдээ хамгийн эерэг хариултанд 5 оноо буюу хамгийн их оноог өгөх зарчим баримталсан. Статистик шинжилгээний дүнд чанарын хэмжигдэхүүнүүд дунджаас дээгүүр үнэлгээ авч, хувьцаат компаниудын тайлагналын чанар дундаж түвшинд байна гэсэн дүн гарлаа. Үүнд:

- Ойлгомжтой байх чанарын үзүүлэлтийн дундаж 4.0490 гэж гарсан нь санхүүгийн тайлангийн ангилал, уншигдах байдал дунд зэрэг гэдгийг харуулсан.
- Харьцуулагдах байдал 3.2288 гарсан нь санхүүгийн тайлангуудыг харьцуулах боломжтой гэдгийг харуулсан.
- Үнэн зөв байдлын хувьд 4.1667 гэж гарсан нь санхүүгийн тайланд бүх үзүүлэлтийг иж бүрэн хамруулдаг, материаллаг алдаа бага, анхан шатны баримтанд үндэслэн гаргаж байна гэж хариулсан байна.
- Уялдаа холбоотой байх чанарын хэмжигдэхүүний хувьд дундаж нь 3.2745 гэж гарлаа.
- Цаг хугаандаа байх чанарын үзүүлэлт 4.1176 буюу дунджаас дээгүүр байна.


Шинэчлэгдсэн Жонсын загвараар санхүүгийн тайлангийн чанарыг хэмжих нь

Хөрөнгийн биржийн II ангилалд хамрах 89 орчим компаниас 77 компанийг түүвэрлэн авч 2012-2014 оны 3 жилийн санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарыг үнэлэхийн тулд Modified Jones загварыг Eviews 8.1 программ ашиглан үнэлж үзэв. Өгөгдлийг панел өгөгдлийн хэлбэрт бэлтгэж E-views программ руу оруулсан. Панел өгөгдөл нь олон субъектын, олон хугацааны, олон хувьсагчдын мэдээллийн олонлогийг агуулдаг.

$$\text{Ерөнхий тэгшитгэл нь: } Y_{i,t} = \beta_1 + \beta_2 X_{2,i,t} + \dots + \beta_k X_{k,i,t} + u_{i,t}$$

Бидний хамгийн их анхаарал татаж буй асуудал бол дискрипшн аккруэль буюу энэ тэгшитгэлийн үлдэгдэл (алдаа) юм. Энэ үлдэгдэл 0-с ялгаатай байх нь уг компанийн санхүүгийн тайлангийн чанар эргэлзээтэй буюу ашгийн удирлага үйлдэгдсэн гэж үзэж байгаа юм.


Зураг 2. Дискрипшн аккрэуль



Шок үүсгэж байгаа буюу дискрипшн аккрэулийн утга  $+1$  ээс их утга бүхий доорхи таван хувьцаат компани байна. Шалтгаан нь:

- 33 болох “БУ”ХК өр төлбөр өсч нийт хөрөнгө огцом өссөн.
- 48 болох “МН”ХК борлуулалтын орлого өссөн.
- 57 болох “НЭ” ХК авлага огцом өссөн.
- 65 болох “ТИ” ХК борлуулалтын орлого өссөн.
- 69 болох “ХМ” ХК борлуулалтын орлого өссөн байна.

Зураг 3. Дискрипшн аккрэуль гистограм



Дээрх зургаас харахад 231 өгөгдлийн бараг 200 орчим өгөгдөл нь тэг рүү маш дөхсөн буюу  $+0,25$ -с дотогш байна. Эндээс 2012-2014 онуудын хооронд Дархан Зочид Буудал, Харгиа, Эрдэнэт Зандан гэсэн гурван хувьцаат компанийн санхүүгийн тайлангийн чанар 100% байв. (DA=0) Санхүүгийн тайлангийн чанар 80%-90% чанартай тайлан өгсөн дараах 12 хувьцаат компани байна (DA=-+0,02)

Хүснэгт 2. 80%-90%-н чанартай тайлан өгсөн хувьцаат компани

1	АПУ ХК
2	Авто импекс ХК
3	Адуун чулуун ХК
4	Баянгол зочид буудал ХК
5	Бөөний худалдаа ХК
6	Женко тур бюро ХК
7	Монгол савхи ХК
8	Монгол шилтгээн ХК
9	Монголи Девелопмент Ресорсес ХК
10	Сонсголон бармат ХК
11	Түшиг Уул ХК
12	Хорин хоёрдугаар бааз ХК

Өөрөөр хэлбэл нийт 77 хувьцаат компаний 15 нь буюу 19.5% нь чанартай тайлан өгсөн байхад үлдсэн 80.5 % нь ямар нэг хэмжээгээр ашгийн удирдлага хийдэг байна гэж дүгнэж болохоор байна.

### Дүгнэлт

1. Судалгаанд 77 хувьцаат компанийг хамруулан ерөнхий нягтлан бодогчдоос нь асуулгын аргаар судалгаа авахад санхүүгийн тайлагналын чанар дундаж (3.7 оноо) түвшинд байна гэж гарсан. Өөрөөр хэлбэл уг 77 хувьцаат компаний удирдлага болон ерөнхий нягтлан бодогч СТОУС-г дундаж хэмжээнд буюу 74%-тай дагаж мөрдөж байна гэж үнэлсэн байна. Асуулгыг байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж тайлагнах үүрэг хариуцлага бүхий этгээдүүдээс авсан тул өөрөө өөрийгөө үнэлэх эрсдэлтэй байж болох тул тодорхой загваруудыг ашиглан үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн.
2. Modified Jones загвараар үнэлж үзэхэд 231 өгөгдлийн бараг 200 орчим өгөгдөл нь тэг рүү маш дөхсөн буюу  $+0,25$ -с дотогш байна. Үүнээс 2012-2014 онуудын хооронд нэр бүхий гурван хувьцаат компанийн

- санхүүгийн тайлангийн чанар 100% байв. (DA=0) Санхүүгийн тайлангийн чанар 80%-90% чанартай тайлан өгсөн 12 хувьцаат компани байв. (DA=-+0,02) Шокийн нөлөөтэй буюу дискришн аккруэлийн утга +1 ээс их утга бүхий таван хувьцаат компани байна.
3. Modified Jones загварын үр дүнгээс харвал нийт 77 хувьцаат компаниудын 15 нь буюу 19.5% нь чанартай тайлан өгсөн, үлдсэн 80.5% нь ямар нэг хэмжээгээр ашгийн удирдлага хийдэг буюу чанаргүй байна гэж дүгнэж болохоор байна.
  4. Нийт судалгаануудаар дүгнэж үзэхэд асуулгаар 74%, Modified Jones загвараар 19.5%, орчны судалгаагаар 51.4% байв. Өөрөөр хэлбэл хөрөнгийн бирж дээ бүртгэлтэй 77 хувьцаат компаниудын санхүүгийн тайлангийн чанар 48.3% байна.

### **Зөвлөмж**

1. Ихэнх улс орнуудад санхүүгийн тайлангийн мэдээллийг СТОУС-д нийцүүлэн бэлтгэж байгаа эсэхийг нэгдсэн нэг тогтолцоо бүхий байгууллага хянадаг. Гэтэл манай улсын хувьд энэхүү хяналтыг нэгдсэн тогтолцоогоор бус тус тусдаа хянахаар хуулиндаа заасан байдаг нь хяналтын үйл ажиллагааг сулруулах сул талтай гэж үзэж байна. Манай улсын хувьд НББ-ийн Мэргэжлийн хувьд хэд хэдэн байгууллага байдаг бөгөөд тэдгээр нь хоорондоо уялдаа холбоо муутай ажилладаг. НББ-ийн мэргэжлийн олон нийтийн байгууллагуудын чадавхи, тэдний ажлын уялдаа холбоог сайжруулах, гүйцэтгэх үүрэг оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.
2. Олон Улсад НББ-ийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөөд шууд нягтлан бодогчоор ажиллах боломжгүй байдаг ба тодорхой хугацаа болсны дараа шалгалт өгөх замаар нягтлан бодогчийн мэргэжлээр ажиллах эрхээ авдаг туршлага байдаг. Ингэж шалгуур тавьснаар НББ-ийн мэргэжилтэний чадавхи өсөх боломжтой юм. Энэ туршлагыг Монгол Улсын хувьд нэвтрүүлэх боломжийг судалж үзэх шаардлагатай хэмээн үзэж байна. Зарим Улс оронд НББ-ийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөгчдөд болон Мэргэжлийн зэрэг олгоходоо “Практик туршлагыг үнэлэх боломжгүй” гэсэн тэмдэглэгээ бүхий диплом, сертификат олгодог байна. Тодорхой хугацааны дотор тодорхой чиг үүргийг практикт хэрэгжүүлсэн тохиолдолд “Практик шалгуур хангасан” гэж үздэг байна.
3. Судалгааны үр дүнгээс үзвэл НББ-ийн тогтолцоо, мэдээллийн чанарт сайн их нөлөө үзүүлэх боломжтой хүчин зүйлс болох компаний

засаглал болон ёс зүйн түвшин муу болон дундаас доогуур байгаа нь энэ чиглэлд тодорхой арга хэмжээг авах шаардлагатай харуулж байна. Хамгийн сайн үнэлгээг технологийн орчин авсан боловч программ хангамжинд хэт найдах эрсдлийг дагуулж болзошгүй юм.

4. Төрийн засаглалын алдааг залруулах, төр бизнесийн үйл ажиллагаанд хэт их оролцож байгааг зогсоох. Тухайлбал, төрийн өмчит үйлдвэрийн газрын ТУЗ, гүйцэтгэх удирдлагыг төрийн оролцоотойгоор байгуулдаг ба ингэхдээ ихэвчлэн улс төрийн томилгоо хийдгийг зогсоох шаардлагатай байна. Судалгаанаас үзвэл төрийн өмчийн оролцоотой компаниудын ТУЗ-ийн нийт гишүүдийн 75 хувийг Төрийн өмчийн хороо болон Засгийн газрын яам агентлагийн төлөөлөл бүрдүүлж байна. Мөн татварын бодлогыг тогтвортой хадгалах шаардлагатай байна.
5. Улсын бүртгэлийн системд шинэчлэл хийдэг хурдыг нэмэгдүүлэх боломжийг судлах. Энэ системийн тусламжтай бизнесийн хэмжээнээс хамаарсан уян хатан санхүүгийн тайлагналын загвар бий болгох, татварын тогтолцоог мөн энэ ажилтай уялдуулан авч үзэх. Ялгаатай тайлагналын загваруудын нэгтгэлийг мэдээллийн системийн тусламжтайгаар хийх боломжийг судлах. Төрийн хэрэгжүүлэгч болон хяналтын байгууллагын нэгдсэн нэг мэдээллийн санг бий болгох улсын хэмжээний программын архитектурыг хийх
6. Нягтлан бодогч мэргэжлийн ангилал бий болгох (анхан, мэргэжлийн, мэргэшсэн гэх мэт)
7. Ёс зүйн түвшинг сайжруулах арга зам судлах, ёс зүйн кодын дүрэмд суурилсан /хууль/ хэлбэрээр баталж мөрдүүлэх ба хариуцлагын тогтолцоог сайжруулах.
8. СТОУС, АОУС-г өөрийн улсын онцлогт тохируулан сайжруулах

#### **Ашигласан материал:**

1. Болормаа,Б. (2014). Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлагналд олон улсын стандартыг нэвтрүүлэх зарим асуудал. Бизнесийн удирдлагын ухааны диссертац, Монгол Улсын Их Сургууль-Эдийн Засгийн Сургууль
2. Гунгааннямбуу,Ц. (2006). Санхүүгийн тайлагналын үндэсний стандартын онол аргагүйн тулгамдсан асуудал. Бизнесийн удирдлагын ухааны диссертац, Монгол Улсын Их Сургууль-Эдийн Засгийн Сургууль
3. Дариймаа,Р. (2016). Жижиг, дунд аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийг боловсронгуй болгох нь. Бизнесийн удирдлагын ухааны диссертац, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль-Эрдмийн Сургууль

4. Цэнд-Аюуш, Т. (2012). Монголын компанийн засаглалыг сайжруулах арга замууд. Бизнесийн удирдлагын ухааны диссертац, Монгол Улсын Их Сургууль-Эдийн Засгийн Сургууль
5. Дэлхийн Банк, Олон Улсын Валютын сан, (2008). Нягтлан бодох бүртгэл, аудитын талаар Стандарт Дүрэм Журмын Хэрэгжилтэнд Өгсөн Үнэлгээний Тайлан
6. Дэлхийн банк, (2009). Компанийн засаглалын талаар Стандарт Дүрэм Журмын Хэрэгжилтэнд Өгсөн Үнэлгээний Тайлан
7. Компанийн Засаглалын Хөгжлийн Төв, (2011). Компаний засаглалын үнэлгээний тайлан
8. Leonard, N. (2000). Discretionary-Accruals Models and Audit Qualifications. Eli Bartov Stern School of Business New York University
9. B. Brian Lee, William Vetter. (2015). Critical Evaluation of Accrual Models in Earnings Management Studies. Journal of Accounting and Finance Vol. 15(1), Prairie View A&M University
10. Tianran CHEN. (2011). Analysis on accrual-based models in detecting earnings m Anagement. Journal of Banking, Finance and Economics Volume 2 2010/2011
11. Md. Aminul Islam. (2011). Is Modified Jones Model Effective in Detecting Earnings Management? Evidence from A Developing Economy, School of Business Innovation and Technopreneurship University Malaysia Perlis, Malaysia
12. Youngok Kim. (1998). Determinant of Financial Reporting System. Dissertation of Ph.D, University of New South Wales
13. Ahmad A. J. A. (2013). The impact of using accounting information systems on the quality of financial statements submitted to the income and sales tax department in Jordan. European Scientific Journal edition vol
14. Ksenija Černe. (2007). Influential factors of country's accounting system development
15. Buchanan, F.R. (2003). International accounting harmonization: Developing a single world standard, Business Horizons, May – June, 61 – 70.
16. D' Arcy, A. (2001). Accounting classification and the international harmonisation debate – an empirical investigation», Accounting, Organizations and Society
17. Gray, S.J. (1998), Towards a Theory of Cultural Influence on the Development of Accounting Systems Internationally, ABACUS
18. Barth M, Landsman W and Lang. (2007). International Accounting Standards and Accounting Quality. Journal of Accounting Research